

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.04.25

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлыг, хурал хийхээр товлосон зарын дагуу 2025.4.25-ны өдрийн 14 цагт Компанийн хурлын танхимаас цахим хэлбэрээр шууд дамжуулав.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2022.04.25-ны өдрийн “Хүчин төгөлдөрт тооцох тухай” №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга Ү.Номин уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Ү.Номин : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 1.023.703 ширхэг хувьцаа эзэмшсэн 3.939 хувьцаа эзэмшигчдээс саналын эрх бүхий 887.485 ширхэг хувьцаа эзэмшсэн 114 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна. Энэ нь нийт хувьцааны 86,69 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн “Хурал хүчин төгөлдөрт тооцсугай” гэв.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурал дарга тус компаний дэд захирал А.Наранцацрал нээж үг хэлэв. Хувьцаа эзэмшигч та бүхэн маань “Талх Чихэр” ХК-ийн пэйж хуудсанд хандан цахимаар болон өөрийн биеэр саналаа өгөцгөөсөн, одоо хурлын үйл ажиллагаанд цахимаар оролцохыг урьж байна гэв. Дараа нь хурлын дэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнийг нөхөн сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 450 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал Л.Баттөр илтгэв.
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн ерөнхий нягтлан бодогч, санхүү эрхэлсэн дэд захирал Д.Эрдэнэцэцэг тайлагнав.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн товч намтарыг ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Баярсайхан танилцуулав.
4. “Ногдол ашиг хуваарилах” тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.

Асуулт №1

Хүнсний аюулгүй байдал сүүлийн үед их яригдаж байна, баталгаатай чанартай гэж танай бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэдэг, энэ тал дээр ямар ажил хийж байна вэ?

Хариулт №1

“Талх Чихэр” ХК нь Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд цаг ямагт анхаарч ажиллаж байгаа. Тэр хүрээндээ Чанарын удирдлагын тогтолцоо, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог салбартаа анхлан нэвтрүүлсээр ирсэн. Энэ удаад ч Хүнсний аюулгүй байдлын менежментийн иж бүрэн тогтолцоо буюу FSSC 22000 V6 стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд эхний шатны аудитаа амжилттай хамрагдлаа. Ингэснээр түүхий эд хүлээн авахаас хэрэглэгчийн гарт хүрэх хүртэл бүхий л шат дамжлагадаа хүнсний аюулгүй байдлыг бүрэн баримталж, хэрэглэгчдээ итгэл даасан, эрүүл бүтээгдэхүүнийг хүргэх боломжтой болж байна. Техник тоног төхөөрөмжийн хөгжил жил ирэх тусам хурдацтай хөгжиж байгааг бид мэднэ ээ. Энэ ч утгаараа сүүлийн 20 жил инноваца хөрөнгө оруулалтын ажлыг амжилттай хийсээр ирсэн. Өнгөрсөн 40 жилийн түүхт ойн хүрээнд бид хэрэглэгчдэдээ зориулсан Онцгой брэндийнхээ төрлийг нэмж, Мальмикс болон сүүтэй гэсэн 2 төрлийн талхыг шинээр үйлдвэрлэж, хүргээд байна.

Асуулт №2

Ажил хийх хүн олдохгүй байгаа гэж дэлхий нийтээр ярих болсон. Танайх ажилчдаа хэрхэн удаан тогтвортой ажиллуулж байгаа вэ?

Хариулт №2

“Талх Чихэр” ХК-ийн ажилчид бол бидний үнэт зүйлс билээ. Энэ хүрээндээ тогтвортой ажлын байрыг бий болгохын тулд олон төрлийн ажлыг зохион байгуулж байгаа. Үүнээс онцолбол:

Компанийн хэмжээнд сэтгэлзүйч ажиллаж байгаа бөгөөд сар бүр өөр өөр тодорхой сэдвийн хүрээнд тогтмол сургалт зохион байгуулж байгаа бөгөөд ажилчдад ч бас эерэгээр нөлөөлж байгаа нь илт харагдах болсон. Мөн Компанийн дотоод арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг онцолбол, Монгол хүн байнадаа аян, Урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн багц шинжилгээ зэрэгт хамруулан ажиллаж байна. Ажилчдынхаа ажлын байрыг тухтай байлгах, хөдөлмөрийг хөнгөвчлөх зорилгоор даралттай усаар зуурмагийг зүсч, хэв үүсгэх шинэ тоног төхөөрөмжийг суурилуулаад байна. Мөн Талхны үйлдвэр, Нарийн боовны үйлдвэр 5000 орчим лист, тэргэнцэртэй. Бүгдийг гараар угаадаг байсан. Нэг угаахдаа 24.000 литр ус хэрэглэгддэг байсан бол Somangil компанийн лист тэргэнцэр угаах тоног төхөөрөмж суурилуулсанаар 2000 литр усаар угаах боломжтой бөгөөд усаа цэвэршүүлэн дахин хэрэглэх боломжтой. Үүнээс гадна компанийнхаа орц гарцын тоог нэмэгдүүлснээр онцгой байдлын үед үүсэх аливаа эрсдэлийг бууруулах бүрэн боломжтой болж байна.

Асуулт №3

CU, GS25, /Emart esvel careffore / гэх мэт гадны franchise их орж ирж байна. Хүмүүс ч их үйлчлүүлж байгаа. Энэ тал дээр танайх хэрхэн анхаарч ажиллаж байгаа вэ?

Хариулт №3

Өнөөдрийн байдлаар “Талх Чихэр” ХК 3500 гаруй харилцагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ дунд та бидний сайн таны гэртэй ойрхон дэлгүүрүүд болон бүхий л сүлжээ дэлгүүртэй хамтран ажиллаж байгаа. Цаашлаад бид B2B буюу байгууллагын үйл ажиллагаа руу чиглэсэн бүтээгдэхүүнийг тусгайлан үйлдвэрлэж, харилцагчдаа хүргээд байна.

Харилцагч байгууллагуудаа онцлон дурдах юм бол МИАТ, KFC, Lotteria, Bluefin зэрэг олон харилцагчтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа улам өргөжүүлсээр байна.

Асуулт №4

Борлуулалт бол Талх Чихэрийн гол зүйл. Борлуулалтыг жигд хүртээмжтэй хүргэхийн тулд яаж анхаарч байгаа вэ?

Хариулт №4

Борлуулалтын системийг илүү хөгжүүлж, үйл ажиллагаа нь борлуулагч болон харилцагч байгуулллагад хүндрэл үүсгэхгүй байлгахын тулд бид шинэ программыг нэвтрүүлж жил гаруйн хугацаа өнгөрөөд байна.

Мөн цэг орхилгүй өдөр бүр 3000 цэгт шинэхэн талх, нарийн боовоо хүргэхийн тулд хичээнгүйлэн ажиллаж байна. Мөн бид өнгөрсөн 2024 онд автопарк шинэчлэлийн ажлыг эрчимтэй хийж ирлээ. Ингэснээр нийгмийн хариуцлагын хүрээнд хар утаа их хаядаг хуучин автомашинуудыг акталж, нийт тээврийн хэрэгсэлийн 90 гаруй хувийг шинэчилж чадсан байна.

Мөн байгальд ээлтэй, эко хэрэглээг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгын хүрээнд 100% цахилгаан автомашиныг борлуулалт, түгээлтэд ашиглаж байна. Цаашдаа уг тээврийн хэрэгсэлийн тоог нэмэх, нийгмийн хариуцлагын хүрээнд байгальд ээлтэй шийдлүүдийг түлхүү хэрэглэх томоохон зорилт тавин ажиллаж байна.

Хурлын дарга : Үүгээр асуулт хариулт өндөрлөж байна. Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо, тэмдэглэлд тусгагдаж байгаа болно, хойшдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Ү.Номин" Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах тухай" Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг уншиж танилцуулав./ уг тогтоолыг хурлын материалд хавсаргав.

Тооллогын комиссын дарга : Компанийн нийт 1,023,703 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3.939 хувьцаа эзэмшигчдээс хуралд 887.485 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 114 хувьцаа эзэмшигч оролцов.

Тооллогын комиссын тараасан саналын хуудас 114 шихэг, ирсэн саналын хуудас 114 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын тоо 114 ширхэг, асуулга тус бүрээр хүчингүй саналын тоо худас байхгүй байна.

1. Компаний 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 887,485 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
2. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 887.485 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын байхгүй
3. ТУЗ-ийн ердийн гишүүнээр Н.Алтанцэцэгийг сонгохыг зөвшөөрсөн 887.485 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан түдгэлзсэн санал байхгүй
4. 2025 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 91.830.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 887.485 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй
5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 450 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 887.450 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй байна. Нийт ирсэн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ: Дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай " гэж уншив. /Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг хурлын материалд хавсаргав/

Үүний дараа хурлын дарга А.Наранацрал хурлаас гарсан шийдвэрийг уншиж танилцуулав.

Хурлын дарга : Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Тогтоол гарч байна, уншиж танилцуулъя. Тооллогын комиссын дүнг үндэслэн

ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.
2. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.

3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Наранцэцэг овогтой Алтанцэцэгийг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг 91.830.000 төгрөгөөр баталсугай.
5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 450 төгрөгөөр тогтоосугай гэж уншсанаар хурал 15 цаг 30 минутад өндөрлөв

Хурлын дарга



А.Наранцацрал

Тэмдэглэл хөтөлсөн

И.Өлзийбаяр